

ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт
Нүүрс
Төмрийн хүдэр
Зэс
Газрын тос



АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 4-р сарын 18

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

- Алтан гулдмайг улс төрийн хурцадмал байдал, эдийн засгийн хямралын үед үнэ цэнээ найдвартай хадгалах хөрөнгө оруулалт, инфляцийн эсрэг хамгаалалт гэж үздэг.

Тэгвэл даваа гарагт Орос Украины дайны нөлөөгөөр алтны үнэ өсөж 3 сарын дунд үеэс хойшхи дээд түвшиндээ хүрлээ.

Алтны спот ханш 0.5%-иар өсөж унц нь 1984.20 ам.доллар болсон бол АНУ-ын алтны фьючерс 0.8%-иар өсөж 1990.20 ам.доллар болжээ.

- АНУ-ын 10 жилийн хугацаатай Төрийн сангийн үнэт цаасны өгөөж 2018 оны 12 сараас хойшхи хамгийн дээд түвшиндээ хүрчээ.

3 сард БНХАУ-д COVID-19-ын улмаас хөл хорио тогтоосноор эдийн засгийн идэвхжил огцом саарсан ч оны эхний эрчимтэй өсөлтийн үр дүнд эхний улиралд эдийн засаг өсөлттэй гарахаар байна.

Хөрөнгө оруулагчид геополитикийн тодорхойгүй байдал болон ХНС-ийн инфляцийн эсрэг тэмцэл нь эдийн засгийн өсөлтийг бууруулж болзошгүй хэмээн болгоомжилж байна. Ихэнх хөрөнгө оруулагчид ногдол ашиг тараах магадлалтай батлан хамгаалах салбар руу чиглэж байна.

Golomt Capital published on TradingView.com, Apr 18, 2022 09:37 UTC+8

Gold Spot / U.S. Dollar, 4h, PEPPERSTONE O1977.48 H1986.67 L1968.90 C1983.67 +10.37 (+0.53%)



TV TradingView



ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 4 сарын 18

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

ОХУ Украйны дайны улмаас дэлхийн зах зээлд нийлүүлэлтийн хомсдол үүсэж, барууны орнууд ОХУ-д хориг арга хэмжээ авах магадлал өндөр байгаа тул нефтийн үнэ даваа гарагт өссөн байна.

Брентийн фьючерс 1.50 ам.доллар буюу 1.3%-иар өсөж, баррель нь 113.20 ам.доллар болсон бол АНУ-ын баруун Техасын биржийн фьючерс 98 цент буюу 0,9%-иар өсөж баррель нь 107.93 ам.доллар болжээ.

Улаан өндөгний баярын өмнө Европын холбооноос ОХУ-ын газрын тосны импортод хориг тавьж магадгүй гэсэн мэдээлэл гарснаар пүрэв гарагт газрын тосны хоёр гэрээ 2.5%-иас илүү өссөн байна.

Өнгөрсөн 7 хоногт ЕХ-ны засгийн газрууд Оросын түүхий нефтийг хориглох санал боловсруулж байна гэж мэдэгдсэн ч Герман яаралтай хориг тавихыг дэмжихгүй байна гэж дипломатууд мэдэгдэв.

Олон улсын эрчим хүчний агентлагаас ОХУ-ын газрын тосонд 5 сараас эхлэн хориг арга хэмжээ авах, эсвэл худалдан авагчид сайн дураараа татгалзсаны улмаас өдөрт ойролцоогоор 3 сая баррель нефтийн олборлолтыг хааж болзошгүйг анхааруулсан.

ОХУ-ын нефтийн олборлолт 3 сарын эхний хагаст 7.5 хувиар буурсан бол 4 сард бууралт үргэлжилсээр байна.

Европ руу экспортлох эрэлт нэмэгдэж байгаагаар холбоотойгоор АНУ-ын нефтийн зах зээл улам чангарах төлөвтэй байгаа тул АНУ-ын дулааны тосны үнэ огцом өссөн.

ОПЕК болон түүний холбоотнууд ОПЕК+ нь барууны орнуудын олборлолтоо хурдацтай нэмэгдүүлэх шахалтыг няцаасан байна.

Өнгөрсөн 7 хоногт ОПЕК-ийн тайланд дурдсанаар 3 сард олборлолтын хэмжээ нь ердөө 57,000 баррелиар нэмэгдэж, 28,56 сая баррель болжээ.

Дайран дээр давс гэгчээр ням гарагт Ливийн Эль-Феел газрын тосны олборлолтоо зогсоож, Ерөнхий сайд Абдулхамид аль-Дбейбаг огцрохыг шаардсан жагсагчид талбайг эзлэн авсны дараа Зуэйтина газрын тосны боомт мөн экспортоо зогсоосон байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.